



**«ГУТАЛ» ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2017 он

Компанийн зорилт

“Гутал” ХК нь түрээслэгч болон харилцагч байгууллагуудын ая тухтай орчин, зөв боловсон харилцааг эрхэмлэн, компанийнхаа бүхий л үйл ажиллагааг хуулийн хүрээнд ил тод, нээлттэй, шударга зарчмыг баримтлан, ажилчдынхаа нийгмийн асуудал, хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэхийг ямагт эрмэлздэг нь бидний өнөөдрийн амжилтын баталгаа юм.

2016 онд захиалгаар хэвлүүр үйлдвэрлэх, оффис, агуулах, гражийн зориулалтаар үл хөдлөх хөрөнгө түрээслүүлэх үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг гарган батлуулж ажилласан.

Хүний нөөцийн бодлого

“Гутал” ХК нь 2016 онд захиргааны албанд 20, инженер техникийн албанд 8, харуул хамгаалалтын албанд 21 ажилтан нийт 49 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулахаар төсөвлөсөн.

2016 онд ажилчдын ажлын үр дүнг сайжруулах, орон тоон илүүдлийн зохистой арга хэмжээг авснаар цалингийн зардлын төсвийг 9.2 хувиар хэмнэж ажилласан.

1	ᠮᠣᠨᠤᠯᠠᠭᠤᠨ /сая төгрөг/	2016 он		Өөрчлөлт - /хэмнэлт/, +/хэтрэлт/	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувиар
1	ᠮᠣᠨᠤᠯᠠᠭᠤᠨ	292.8	272.0	-20.7	
2	ᠲᠤᠮᠤᠨᠤᠯᠠᠭᠤᠨ	122.4	107.8	-14.6	
3	ᠮᠣᠨᠤᠯᠠᠭᠤᠨ ᠮᠣᠨᠤᠯᠠᠭᠤᠨ	14.4	23.6	9.2	
4	ᠰᠠᠭᠠᠨᠠᠯᠲᠤ	73.2	52.2	-21.0	
5	ᠠᠮᠢᠷᠠᠯᠲᠤ	31.9	33.4	1.5	
6	ᠠᠶᠢᠨᠠᠭᠤᠨ	64.2	54.6	-9.6	
	ᠮᠣᠨᠤᠯᠠᠭᠤᠨ ᠠᠶᠢᠨᠠᠭᠤᠨ ᠠᠶᠢᠨᠠᠭᠤᠨ ᠠᠶᠢᠨᠠᠭᠤᠨ ᠠᠶᠢᠨᠠᠭᠤᠨ	598.9	543.6	-55.3	90.8%

2016 онд хийгдсэн засварын ажлууд

2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Хүнсний коллежийн дулааны худгаас Аварга сургуулийн дулааны худаг хүртэлх 36 жил болсон 130м урт хос Ф200-ын шугам, 130м Ф150 цэвэр усны шугам сольж монтажлах ажлыг 68 сая төгрөгөөр төсөвлөсөн байсныг 55,5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.
- “Гутал” ХК-ийн оффис болон гуанзны барилгын хуучирсан дотор системийн хувиарлах хаалтыг иж бүрэн сольсон.
- Гуанзны барилгын подваль руу машин орох, гарах гарц шинээр гаргах ажлыг 10 сая төгрөгөөр төсөвлөснийг 8,5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. г.м
- “УБДС” ТӨХК-иас элеваторын узелиэр дулаан авахыг хориглосон шаардлагын дагуу Төмөр замын агуулах №1-8-ыг халаалтын цогц төхөөрөмжинд 53.4 сая төгрөгөөр холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ ажлыг төсөвлөөгүй байсан.

2017 онд хийгдэх ажлууд

- Оффисын гадна талбайнаас Хаан банкнаас зүүн тийш хүртэлх 2100 м2 өөрийн талбайг асфальдахад 126.0 сая.төг,
- Төмөр замын дэргэдэх № 3 тоот 900 м2 талбай бүхий хүйтэн агуулахыг дулаантай болгоход барилгын засварт 70.2 сая.төг, сантехникийн засварт 22.0 сая.төг,
- Оффисын болон гуанзны барилгын подвацийг засаж агуулах, үйлдвэрлэлийн зориулалтаар түрээслүүлэх урсгал засварт 12.5 сая.төг,
- Оффисын барилгын 1,2,3,4,5,6,7 давхаруудын урсгал засварт 25 сая.төг,
- Төмөр замын № 1,2,3,4,5,6-р агуулахуудад шинээр бохирын шугамтай холбоход 12.0 сая.төг,
- Оффисын хэрэглээний ариун цэврийн халуун, хүйтэн усны далд монтажийг ил болгох 15 сая.төг,
- Цахилгааны тосон салгуур /Трансформаторын хаалттай дэд өртөөний тоноглол, дагалдах материал, ажлын хөлс/ 40 сая.төг гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгэхээр төсөвлөөд байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд

“Гутал” ХК нь санхүүгийн тайлангаа Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, дүрмийн дагуу явуулж, Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүртгэлээ хөтөлж байна. 2016 онд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй байна.

2016 онд ХУД-ийн Нийгмийн даатгалын хэлтсээс “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөнд”, ХУД-ийн Татварын хэлтсээс 2011 оноос 2015 оныг дуусталх хугацааны санхүүгийн баримтанд “Татвар ногдуулалт, төлөлтөнд” тус тус хяналт шалгалт орж, шалгалтаар татвар ногдуулалт болон баримтын зөрчилгүй гарсан.



Мөн Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 16-ын дагуу үндсэн хөрөнгөнд 3-5 жилийн хугацаанд дахин үнэлгээ хийлгэх шаардлагад нийцүүлэн “Гутал” ХК-ийн өмчлөлийн 56 нэрийн үл хөдлөх эд хөрөнгөнд үнэлгээ хийлгэж, барилгуудын өнөөгийн үнэ цэнийг 8.1 тэр бум төгрөгөөр үнэлүүлсэн.

2016 он эдийн засгийн хямралтай хүндхэн жил болж өнгөрсөн хэдий ч бид харилцагч байгууллагуудаа алдахгүй тогтвортой байлгаж, орлогыг 12.9 хувиар, татварын дараах цэвэр ашгийг 18.4 хувиар тус тус өсгөж чадсан.

“Гутал” ХК-ийн өөрийн хөрөнгийн хэмжээг өнгөрсөн онтой харьцуулахад 6,712.1 сая.төг буюу 85.2 хувиар өсч, 14,588.7 сая.төг-т хүрсэн байна.

Нийт актив 2016 онд 83 хувь буюу 6,760.8 сая төгрөгөөр өсч 14 тэр бумд хүрсэн байна. Компанийн нийт хөрөнгийн сүүлийн 3 жилийн өсөлтийг дараах хүснэгт болон графикаар харуулав.

Балансын үзүүлэлт /сая.төг/	2014 он	2015 он	2016 он
Эргэлтийн хөрөнгө	3,139.4	5,137.5	6,434.2
Эргэлтийн бус хөрөнгө	3,035.5	3,014.7	8,478.8
Нийт хөрөнгийн дүн	6,174.9	8,152.2	14,913.0
Өр төлбөр	272.5	275.6	324.3
Эзэмшигчдийн өмч	5,902.4	7,876.6	14,588.7
Нийт ӨТ ба ЭӨ-ийн дүн	6,174.9	8,152.2	14,913.0



Нийт хөрөнгийн 98 хувийг эзэмшигчдийн өмч, 2 хувийг өр төлбөр эзэлж байна.


Орлогийн дэлгэрэнгүй тайлан

2016 онд 2,851.3 сая төгрөгийн орлогыг төсөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 4,200.4 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Орлогыг өмнөх онтой харьцуулахад 479.7 сая төгрөгөөр буюу 12.9 хувиар өссөн байна. Орлогыг нэр төрлөөр нь задлан харуулав.

№	Орлогын төрөл /сая төгрөг/	2015 оны гүйцэтгэл	2016 оны гүйцэтгэл	Өсөлт /+/, бууралт -/-	
				Мөнгөн дүн	Хувиар
1	Түрээсийн орлого	3,442.2	3,613.7	171.5	5.0%
2	Хэвлүүрийн орлого	25.5	29.3	3.8	14.9%
3	Хүүгийн орлого	250.6	555.1	304.5	121.5%
4	Бусад орлого	2.4	2.3	-0.1	-4.2%
	Дүн	3,720.7	4,200.4	479.7	12.9%

Тайлант жилд 2,325.7 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан. Татварын дараах цэвэр ашгийг өмнөх онтой харьцуулахад 360.8 сая төгрөг буюу 18.4 хувиар өссөн байна.

Үзүүлэлт /сая.төг/	2014 оны гүйцэтгэл	2015 оны гүйцэтгэл	2016 оны гүйцэтгэл	Өөрчлөлт	
				Мөнгөн дүн	Хувь
Нийт орлого	2,902.6	3,720.7	4,200.4	479.7	12.9%
Нийт зардал	1,443.5	1,755.8	1,874.7	118.9	6.8%
Татварын дараах цэвэр ашиг	1,459.1	1,964.9	2,325.7	360.8	18.4%



Төлсөн татвар

2016 онд тус компани нь Нийгмийн даатгалын шимтгэлд 95.5 сая төгрөг, Хувь хіний орлогын албан татварт 155.9 сая төгрөг, Нэмэгдсэн өртөгийн албан татварт 376 сая төгрөг, Аж ахуй нэгжийн орлогын албан татварт 228.4 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 79.0 сая төгрөг буюу нийт улсын төсөвт 934.8 сая төгрөгийн албан татварыг төлсөн байна. Одоогоор ямар нэгэн татвар болон НДШ-ийн өр төлбөргүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төрөл /сая.төг/	2013 он	2014 он	2015 он	2016 он
НӨАТ	145.0	273.0	267.5	376.0
НДШ	85.7	102.3	102.0	95.5
ХХОАТ	98.3	90.7	39.7	155.9
ААНОАТ	80.6	177.9	229.6	228.4
ҮХЭХАТ	44.8	48.0	44.0	79.0
Нийт дүн	454.4	691.9	682.8	934.8

Цаашид шийдүүлэх асуудал

“Гутал” ХК-ийн санхүүгийн тайланд Гутлын үйлдвэр байх үеийн гутлын агентаас үүссэн найдваргүй авлага 325.2 сая төгрөг, 2007 оноос өмнө үүссэн найдваргүй авлага 616.9 сая төгрөг, 2007 оноос өмнө үүссэн төлөгдөхгүй өр төлбөр 7.2 сая төгрөг тус тус байгаа болно.

Иймд дээрх найдваргүй авлага болон төлөгдөхгүй өр төлбөрийг найдваргүйд тооцуулан данснаас хасуулах саналтай байна.

ГУТАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ